

“СОЁЛ ЭРДЭНЭ” ДУУНЫ БАРИМТАТ ТҮҮХ

Цэндийн Наранчимэг^{1,*}
Соном-Ишийн Юндэнбат²

¹ Соёл урлагийн их сургуулийн докторант, Улаанбаатар, Монгол улс

² Доктор (Ph.D), Улаанбаатар, Монгол улс

* Corresponding author: tstsn91@gmail.com

Хураангуй: Монгол улсад уртын болон ардын дуу, найрал дуу, шинэ цагийн дуу хөгжмийг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гавьяатнуудын нэг бол Анандын Амар сайд Алдарт дуучин Магсар хурцын Дугаржав дуучинтай танилцуулсан анхны Алдарт Гавьяат дуучин Жигзавын Дорждагва юм. Ж.Дорждагва нь монголын урт болон ардын дууны хөгжил, түүний хадгалалт хамгаалалт, өвлүүлэн үлдээхэд онцгой анхаарч, авьяас чадвар, ур ухаан, сэтгэл зүрхээ зориулсан билээ. Монголын хөгжмийн урлагийг шинэ шатанд гаргахад дууны судлаач, сурган хүмүүжүүлэгч, багш, хөгжмийн зохиолч байжээ. Ж.Дорждагва 1935, 1936 онд Алдарт дуучин М.Дугаржав нарын уран бүтээлчидтэй хамтран “Монгол урт дуунуудын түүвэр”, “Монгол ардын дуунуудын түүвэр”, 1970 онд 108 уртын дууг ноотлон, “Уртын дуу” номыг хэвлүүлсэн байна. 1933-1942 онд дууны хөгжмийн бүтээлийнхээ гол бүтээлүүдээ туурвисан ба нийт 30 гаруй дууны хөгжмийг, 10 гаруй дууны шүлгийг, 5 уртын дууны хөгжим, үгийг зохиосон байна. Ийм учраас уг, хөгжмийг зохиосон дууны зохиогчийн эрхийг хамгаалахыг зорилоо.

Түлхүүр үг: түүхэн өв сан, тодруулга, оюуны өмч


DOCUMENTARY HISTORY OF THE MONGOLIAN FOLK SONG “SOYOL ERDENE”

Naranchimeg Tsend^{1,*}
Yundenbat Sonom-Ish²

¹ Doctoral student of Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia

² Doctor (Ph.D), Ulaanbaatar, Mongolia

Abstract: The aim of this study is to explore the life and musical contributions of Dorjdagva Jigzav, a renowned singer and composer of Mongolia. It was the Prime Minister of Mongolia, Amar Anand, who first introduced Dorjdagva J. to the famous singer Dugarjav Magsar khurts. Dorjdagva J. was well-known for his work in the



development of long and folk songs, choral singing, and contemporary music. He was committed to preserving and promoting Mongolian music, and his compositions played a significant role in elevating Mongolian music to new level. Additionally, Dorjdagva J. was also a researcher, educator, and teacher of long songs. Together with Dugarjav M. and other composers, he published several collections of Mongolian long and folk songs, including “A Collection of Mongolian Long Songs” in 1935 and 1936, and “108 Long Songs” with their musical notes in 1970. Between 1933-1942, he created his greatest works, which included over 30 songs, more than 10 song lyrics, and 5 pieces of long song music and lyrics. This study is intended to protect the copyright of Dorjdagva Jigzav’s songs, song music and lyrics, recognizing the importance of his contributions to Mongolian music.

Keywords: historical heritage, clarification, intellectual property

Оршил

Ж.Дорждагвын гар бичмэл болон бусад хадгалан үлдээсэн өв санг судалгааны эргэлтэд оруулаагүй зарим нэг зүйл нь алдагдсан, хэн нэгэнд хадгалан байгаа, ялангуяа түүний зохиосон дуунууд, дуулж байсан дуунуудын үг, ая дан алдагдаж байгаа тухай эрдэмтэн судлаачид, дуучдын яриа, 103 урт дуу нутаг нутгийн дуулдаг ая дангаар эгшиглээс¹-т оруулан хэвлүүлсэн “Уртын дуу” (Дорждагва, 1970), мөн түүний хадгалж үлдээсэн алдартнуудын дуулж эгшиглээст буулгасан 25 (1935) оны “Монгол урт дуунуудын түүвэр”, 26 (1936) оны “Монгол дуунуудын түүвэр” ном ховордож улсын болон архивын сан хөмрөгт үлдээгүй зэрэг нь судлах үндэслэл болсон. Н.Жанцанноров, Ж.Энэбиш, Ж.Саруулбуян, Д.Оюунцэцэг нарын эрдэмтэн судлаачид 2012 онд Дорждагва сантай хамтран 110 жилийн ойг тэмдэглэх хурлын үеэр “Дорждагвын өв сан”-г хамгаалах тухай хэлэлцэж байсан. Өвөр Монголд “Суваргань өндөр” дууг манай дуу гэж дуулж байгаа тухай, “Соёл эрдэнэ” дууг Дугаржавын ая (Зууны мэдээ, 2020), “Халх голын баатарчууд” дууны үгийг Д.Пунцаг (Хан эгшиг-2 тоглолт, 2019), Их дуучны талаар хийж гүйцэтгэсэн судалгааны ажил эхлээгүй зэргээс шалтгаалан өв санг хамгаалах нь зүйтэй гэсэн саналыг “Дорждагва сан”-аас гаргасныг үндэслэн судлах дэлгэрүүлэх үүдийг нээж байна. “Дорждагва-110” жилийн ойн ерөнхий зохион байгуулагчаар, “Талын их дуучин” баримтат кинонд зөвлөхөөр, Ж.Энэбиш “Их дуучны яриа” судалгааны номын хэвлэлтийн ивээн тэтгэгчийг урьсан, Их дуучны нэрэмжит урт дууны олон улсын уралдааныг Их газрын чулуунд зохион байгуулах зөвлөлийн гишүүнээр, “Дорждагва-110” гэрэл зураг, өв соёлын үзэсгэлэнг Театрын музейд дэлгэсэн зэрэг эх баримтын судалгааг санаачлан гүйцэтгэсэн байна. Энэ удаагийн өгүүлэлдээ Ж.Дорждагвын хөгжмийг зохиосон дууны түүхийг судалж тодрууллаа.

Судалгааны арга зүй

Олон нийтийн хэвлэлийн мэдээлэл, цахим бичлэгт нийтлэгдсэнийг ажиглан нэгтгэн цуглуулж, эрдэмтэн, хөгжим судлаач нарын аман сурвалжийг бичлэгээр авч баримтжууллаа.

¹ Өрнө дахины 5 шугам эгшиг бичгийн аргаар

“Хөгжилтэй залуусын дотор ер уйтгаргүй бөгөөд эсхүл хангинатал дуулна, эсхүл элдэв уран хошин үгсийг хэлэлцэнэ. ...Энэ нэгэн бүлэг хөгжилтэй залуус нь уран авьяасын уран хошин чадвартай хүмүүс тул ер үзсэн сонссон ямар нэг хэргийг энгийн үл өгүүлнэ” (Монгол ардын үндэсний соёлын зам, 1935) гэж бичжээ. Тэр бол Улсын төв театрын уран сайхны хэсэг залуус, нийт 35 уран бүтээлч Тагна Тува улсад урилгаар тоглохоор яваа нь энэ ажээ.

Идэр залуусын дунд Насан-Очирын Наваан-Юндэн, Жигзавын Дорждагва нар дуу шуу болон хөгжилдөж явсан байна. Урлагийн энэ тоглолтод уг дууны шүлгийг зохиосон.



Зураг 2. Их дуучин Ж.Дорждагва, Насан-Очирын Наваан-Юндэн нар. 1975 он

Н.Наваан-Юндэн, аялгууг зохиосон Ж.Дорждагва нар нэг “гал” болж явсан байдаг. Тэр үед орон нутагт дэн буудал, хоол зоогийн газар гэж байсангүй. Энэ бүхнийг “гал”-ууд өөрсдөө зохицуулдаг байсан цаг. Урлагийн тоглолтоор явахад нэг “гал” болж явна гэдэг бол дундаа аян замын хүнс, аяганы хийц нэгтэй бөгөөд урт холын аянд амин зуулга, ажил үйл, санаа сэтгэл нэгтэй явахын нэр юм. Ийнхүү нэгэн “гал” болж явахдаа хоёул хамтарч дуу зохиохоор тохиролцсон байна. Тэр үед “Үхэрчин хүү”, “Баян Монгол”, “Идэр жинчин”, “Жавхлант сүрэг” (Батсүрэн, Энэбиш 1971, 36) зэрэг шинэ дуунууд гарсан боловч мал аж ахуйн сэдэвтэй дууны зэрэгцээ улс төрийн талаар бас дуу хэрэгтэй байна гэж тэд үзжээ.

Ийм дуу зохиох санаа сэдэл төрөхөд тухайн оны эхээр зарласан дууны шүлгийн уралдаан чухал түлхэц болсон байна. Энэ уралдааны зорилго нь 1936 онд болох улс хувьсгалын 15 жилийн ойд зориулсан шинэ дуу, шүлгийг арвижуулж, үндэсний уран сайхныг хөгжүүлэхэд чиглэгджээ. Уг уралдааны удирдамжид нам засгийн явуулж байгаа ажил хэрэг, улсыг батлан хамгаалах, улсын эдийн засаг, мал аж ахуй, үйлдвэр худалдаа, соёл боловсролын хөгжил, ард түмний жаргалант тайван байдал, тус орны байгаль дэлхийн баялаг, элдэв гайхамшигт зүйлийг магтаж, ард түмний эв нөхөрлөл, элбэрэл журмын элэгсэг найртай ёс зэргийг уран яруу үзүүлэхийг болзол болгон дэвшүүлсэн байжээ. Энэ хоёр зохиогч урьд

нь Магсар хурцын Дугаржавын мал аж ахуйн тухай гайхамшигтай дуунуудыг бүтээх үйл явцад аль аль нь оролцож явсан бөгөөд Ж.Дорждагвын хувьд уг дууг зохиох үйл явцыг өөрийн нүдээр үзэж, биеэр оролцсон тул энэ талаар эрх биш ойлголттой, бага боловч туршлагатай байсан гэж болно. Дугаржав дуучны энэ туршлагад тулгуурлаж, нам засаг, ард түмэн, цэрэг эрсийг магтсан дуу хамтран зохиохоор шийдэж, энэ зорилгодоо нийцүүлэн тэдний зохиосон “Соёл эрдэнэ” хэмээх дуу нь анх “Хайртай Монгол орон” хэмээх нэртэй байжээ. Уг дууны аяыг Ж.Дорждагва зохиохдоо; Дугаржав багшийнхаа аялаад гардаг шинж, ерөнхий зургийг шингээсэн, хэн хүнгүй дуулмаар, мартагдамгүй зохиомжтой аялгуу хийх зорилгыг өмнөө тавьжээ. Дугаржав багшийнх нь “аялаад гардаг шинж” гэдэг нь юу вэ? гэвэл; “Аливаа дууны аялгууг чихний сонор сайхан мэдрэлээр татаж, тархи ухааны уран сайхан мэдрэлд тогтоох, хоолойн донж, гоо сайхан мэдрэлээр үгний хуваарь, хэмжээ хийцийг чимэглэн гаргасны хойно сая энэ гурван уран нийлээд яруу найруулга бүхий уран сайхны аялгуу бүрдэж чадна” (Монголын үндэсний соёлын зам, 1934) гэсэн онол, арга зүйн баримтлал юм.

Ж.Дорждагва “Соёл эрдэнэ” дууныхаа аяыг зохиохдоо, багшийнхаа дээрх айлдварыг баримжаа болгож, улмаар ардын дууны хэлбэрийг сонгон, “Зээ хө” гэсэн аялга уртын дуунд байдаг бол богинын дуунд хийгээд үзье хэмээн туршсан нь уг дууны амьдрах чадварыг бататгасан амин чухал шийдлийн нэг болж чадсан байна. Үүнтэй холбогдуулан дурдахад, монгол ардын уртын дуу “Зээ”, “Заа”, “Жоо”, “Зэхүй ээ” гэсэн тусгай эхлэлтэй байх нь түгээмэл. Эдгээр нь эртний монголчуудын “Зээ” гэсэн эхлэх урианаас улбаатай үг, аялгын хувилбарууд гэж болно. Найр хуримын эхэнд ерөөлч хүн ерөөл айлдахдаа “Зээ” гэж уртаар уянгалуулан эхэлдэг, төр ёсны айзам уртын дуу “Зээ” гэсэн уухайн аялгаар эхэлдэг нь эртний тэр эхлэх урианаас улбаатай ажээ (Мандах, 2022, 74).

Н.Наваан-Юндэн өөрийн шүлгэндээ анх “Зээ хө” гэдэг үгийг хэрэглээгүй. Харин Ж.Дорждагва уг шүлгэнд ая зохиохдоо “Зээ” гээд эхэлдэг уртын дууны хийц маягийг энэ дуунд дуучин хүний торгон мэдрэмж, зөн билгээрээ оруулж өгсөн нь уг дууны амьдрах чадварыг бататгасан оновчтой шийдлийн нэг болж өгсөн байна. Хэрвээ “Зээ хө” байхгүйгээр шууд “Соёл эрдэнийн” гэж эхлэх нь зохимжгүй байсан хэрэг. Уг дуунд “Зээ хө” гэсэн угтвар аялгыг нэмснээр нэгдүгээрт, хүмүүсийн анхаарлыг уг дуунд татах, тэрчлэн өөрөө хоолойгоо цэгцлэх, өнгө авах, амьсгаагаа зохицуулахад нэн зохимжтой болсон байна.

Мөн уг дуунд:

“...Сүртэй улаан туг нь намилзан мандсан хө хө хө

Сод мэргэн хувьсгалын цог жавхлан төгөлдөр хө хө хө...” гэсэн бараг мөр болгоны төгсгөлд “хө хө хө” гэсэн монгол дууны дуулах уран сайхны аргад нэн тохиромжтой бөгөөд тодорхой утга илэрхийлдэггүй нэгэн хэлц аялгууг нэмэлт болгон хэрэглэсэн нь тухайн дууны аяыг улам уран тансаг болгох хэрэглүүр болсноороо онцлог юм. Монгол ардын дуу, тэр дундаа халх чиглэлийн дуунд “хө” оруулан дуулдаг заншил түгээмэл байдаг. Энэ бол дууны яруу найрагт үг хомсдож, аялгуунд гүйцээж оруулсан хий дэмий оруулга биш харин ч дууны шүлгийн шад, тухайлбар бүрийг гийгүүлэгчээр бус эгшгээр төгсгөж, аялгууны дуулалт чанарыг алдагдуулдаггүй тийм онцлог оруулга юм. “Хө, хө”-г оруулж дуулснаар уг дууг

сонсогчдод ойртуулж, найртай дотно бөгөөд сонсголонтой болгодог удвистай гэж болно. Үүнийг Төрийн хошой шагналт хөгжмийн зохиолч, ШУ-ны доктор (Sc.D) Н.Жанцанноров “Хө хө-гөөр...сонсогч олонтойгоо дотносон холбогдох, хамтран дуулах дотоод хэлбэр” хэмээн тодорхойлсон байдаг.

Ж.Дорждагвын “Соёл эрдэнэ” дуунд ардын богино дууны нугалаа хугалаа, чөлөөт сэтгэлгээ бүрэн шингэснээрээ М.Дугаржавын “Баян монгол” дуутай ойр төстэй байдаг нь тэр үеийн уран бүтээлчид өв соёлынхоо хөрс суурьтай баг холбоотой байсныг баглан харуулдаг. Тэр үед Дорждагва гуай ноотны мэдлэг хараахан эзэмшээгүй байсан цаг. Хөгжмийн шүүмж судлаач, Монголын консерваторийн багш С.Энхбулаг “Тэрбээр ноот мэддэггүй байсан нь зөв байж. Ноот мэдэхгүй тулдаа аз болж ийм дуу бичсэн байна. Хэрвээ ноот мэддэг байсан бол европын тогтолцоонд хүчээр захирагдаж, баригдаж бичих байсан” хэмээн дуу алдан хэлсэн байдаг. “Соёл эрдэнэ” дуунд монгол ардын дууны гайхамшигт нууц эд эсийн нэгэн болох холын үсрэлтүүд, өргөн царааг чадамгай ашигласан байдаг” (Батсүрэн, Энэбиш, 1971, 50) хэмээн дүгнэсэн нь буй. Уг дуу зохиомжийн хувьд эхлэл, өрнөл, оргил, төгсгөл гэсэн төгс зохиомжтой бөгөөд “Зээ хө” нь эхлэл, “Засгийн минь алдар аа хө” гэдэг нь төгсгөл болж, уул дууны шүлгийн бадаг, эхлэл төгсгөлийн хоёр баганыг холбосон шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, энгийн байдлаар эхлээд, аялгууны хөгжил улам улам бадрангуй болон өрнөсөөр цааш үргэлжлэн дэвшсэн хөдөлгөөнөөр оргилдоо хүрч, “Засгийн минь алдар аа хө” гэдгээр багжин дуусаж байна (Цэдэв, Утга зохиол урлаг, 1975).




Зураг 3. Ж.Дорждагвын хувийн сан хөмрөгөөс

Ингэж яруу найрагч, хөгжмийн зохиолч хоёр хамтарч “Соёл эрдэнэ” гэсэн сод сайхан дууг шүлэг, аялгууны нарийн зохицол шүтэлцээтэй туурвин бүтээж чадсан нь сонсогчдын зүрх сэтгэлд баяр баясгалангийн галыг бадраан, хөдөлмөрлөх үйлсэд урам зориг нэмж, үе дамжин дуурсахын увдисыг олсон ажээ. Ж.Дорждагва “Соёл эрдэнэ” дуунаас гадна “Туулай би”, “Агуу ялалт”, “Эрэлхэг чекист”, “Халхын голын баатарчууд”, “Ёслогч”, “Сүхбаатарын гэрээс”, “Цуурай”, “Сүрт жагсаал”, “Малчид”, “Майн нэгэн”, “Манай нам”, “Соёлын угтлага”, “Баясгалант амьдрал” зэрэг олон дууны хөгжим, “Энэ хөндийн балгас”, “Нам төр”, “Суваргань өндөр”, “Сэнсийн цагаан үүл”, “Энхийн уриа” уртын дууны үг аяыг зохиосон бөгөөд түүний хийсэн бүтээл нь ганцхан “Соёл эрдэнэ” байлаа ч гэсэн монголын соёл урлагийн түүхэнд мөнхөд үлдэх ёстой үнэ цэнтэй сод бүтээл мөн.

Дүгнэлт

Их дуучин Жигзавын Дорждагвын байгалиасаа заяасан төрмөл авьяаст өвлөгдөн ирсэн монголын урт болон ардын дуу, түүний олон хувилбар бүхий дуулсан дууны соронзон хальсны бичлэгүүд, эгшиглээст үлдээсэн дууны ном, дуунуудын үгийг бичиж үлдээсэн гар бичмэлүүд, судлаачдад хэлж үлдээсэн амьд ярилцлагын хуурцгууд, хэдэн арван гэрэл зураг байна. Эдгээр соёлын биет бус өвийг нэгтгэн баримтжуулж, хувийн сан хөмрөгийг үүсгэж, бүтээлүүдэд зохиогчийн эрхийг баталгаажуулах нь зүйтэй.



Зураг 4. Ж.Дорждагвын гар бичмэл, 1965

Ж.Дорждагватай холбоотой дагнасан судалгааг хийснээр монголын урт болон ардын дууны салбарт суралцаж байгаа суралцагсад, мэргэжлийн урлагийн байгууллагын дуучдад, ялангуяа залуу үеийнхэнд өвлүүлэн үлдээх, эрдэмтэн судлаачдад гарын авлага болох мэдээллийг цуглуулж, нэгтгэж, шаардлагатай судалгааг хийснээр давуу тал, ач холбогдолтой, үнэ цэнтэй болно.

Ашигласан материалын жагсаалт

Ном:

1. Ардыг гэгээрүүлэх яамны хэвлэл. 25 (1935) /дахин хэвлэлт 2021/. *Монгол дуунуудын түүвэр*. Улаанбаатар, Монгол Улс: Улсын хэвлэлийн газар.
2. “Монгол ардын үндэсний соёлын зам”. 1934. №1.
3. “Монгол ардын үндэсний соёлын зам”. 1935. №5.
4. Лувсанвандан, С., Жамсранжав, Г. 1968. *Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх (1921-1965)*. Улаанбаатар, Монгол Улс: Улсын хэвлэлийн газар.
5. Батсүрэн, Д., Энэбиш, Ж. 1971. *Дуунаас дуурь хүрсэн зам*. Улаанбаатар, Монгол Улс: Улсын хэвлэлийн газар.
6. Саруулбуян, Ж. 1973. *Баатар ван Наваан-Юндэн*. Улаанбаатар, Монгол Улс: Улсын хэвлэлийн газар.
7. Цэдэв, Д. 1975. “Соёл эрдэнэ-сод сайхан дуу.” *Утга зохиол урлаг сонин*, 1975.11.21. №46.
8. Жанцанноров, Н. 1989. “Монгол дууны “хө-хө-хө”.” *Утга зохиол урлаг сонин*. 1989.04.28. №18 /1700/
9. Эх соёл эх бичиг. 2020. “Соёл эрдэнэ.” *Зууны мэдээ*, 2020.10.14.
10. Юндэнбат, С. 2022. “Найр наадмын манлай уртын дуу, үүрэг, үнэ цэн.” *Соёлын орон зай: Үндэсний үнэт зүйл*. Ред. Мандах Доржпалам. Улаанбаатар, Монгол Улс: Линограф.

Аман сурвалж:

1. Самбуугийн Энхбулагтай хийсэн ярилцлага. 2023. Улаанбаатар хот: Монгол Улсын консерватори.

Цахим эх сурвалж:

1. Наваан-Юндэн, Оюундарь. 2018. ““Баатар ван Наваан-Юндэн”-гийн мэндэлсний 110 жилийн ой Эрдэм шинжилгээний хурал.” 2018.12.26. Дүрс бичлэг. 5:40. <https://www.youtube.com/watch>